

## Соёл хоорондын харилцаанд холбогдох зарим ажиглалт

Доктор, профессор Т.Дорждагва

Сүүлийн жилүүдэд манай орны гадаад харилцаа өргөжин хөгжиж, соёл хоорондын харилцаанд тодорхой өөрчлөлтүүд гарах боллоо. Соёл хоорондын харилцаан дахь нэг чухал асуудал бол орсоор аккумулярация, англиар acculturation гэдэг үзэгдэл болно. Аккумулярацийн тухай "Ард түмнүүд өөр хоорондоо харилцах явцад аль нэгэн ард түмэн нөгөө ард түмнийхээ соёлын хэлбэр, төрх шинжүүдийг эзэмшин авах үйл явц юм. Аккумулярацийг урт удаан хугацаанд шууд харилцан үйлчилсэний үр дүнд нэг нийгэм буюу угсаатны бүлгээс нөгөөд нөлөөлөх нөлөөлөл гэж хүн судлалд үздэг. Аккумуляраци нь соёлын нэвчилт (диффузия –Т.Д.)-ийн нэгэн хэлбэр, тэрчлэн соёлын холбоо харилцааг тэмдэглэдэг" /5. 17/, "Нэг ард түмний соёл өөр ард түмний, гэхдээ ихэвчлэн илүү хөгжилтэй ард түмний соёлыг бүхлээр нь буюу хэсэгчлэн хүлээн авахад хүргэх соёлуудын харилцан нөлөөллийн үйл явцыг тэмдэглэх (АНУ-д ХХ зууны 30-аад онд буй болсон) угсаатны зүй, соёл судлалд хэрэглэгдэх латин хэлний гаралтай нэр томъёо юм" /4. 18/ гэж тус тус нэвтэрхий толь бичгүүдэд тэмдэглэжээ. Гэхдээ бид энэ удаад эдгээрийг өөрсдийн үзэл баримтлалын үүднээс түншин шинжиж үнэлэх зорилго тавиагүй болохоо энэ дашрамд илэрхийлье.

Аккумулярацийн явцад өөр хоорондоо ялгаатай соёл бүхий ард түмнүүдийн газар нутаг, нэр уснаас авахуулаад идэж уух хоол унд, өмсөж зүүх хувцас хунар, гоёл чимэглэлийн зүйлс, амьдран суух орон байр, орчин, үзэл бодол, шашин шүтлэг нь хүртэл тодорхой утгаар өөрчлөгдөж болох ажээ. Гэтэл хамгийн тогтвортой бөгөөд тухайлбал соёлыг түрэмгийлэх хийгээд устгах, уусгах бодлого, үйл ажиллагаа хэрэгжлээ гэж бодоход тэдгээрт хаалт саад, "цайз" болж үлддэг нь хэл байдаг байна /3. 44/. Манай орчин үеийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг, их зохиолч Д.Нацагдорж нэгэнтээ:

*өсөхөөс сурсан үндэсний хэл мартаж болшгүй соёл  
үхтэл орших төрөлх нутаг салж болошгүй орон*

гэж хэл соёл, нутаг орныхоо тухай сэтгэлд хоногштол тун онож шүлэглэжээ.

Уг асуудлыг бид нэн холоос эхлэж олон талаас нь авч үзэхийг түвдсэнгүй. Харин ч илүү ойрхоноос, өөрөөр хэлбэл манай ахан дүү өвөрлөгчдийнхөө жишээн дээрээс авч үзэхийг зорьсон болой. Ингэснээр бидний тэлилуулан буй асуудлын гогцоог илүү тодорхой бөгөөд хялбархан илэхийлэхэд боломжтой байсан бөгөөд бусад хэлнүүдийн хувьд энэ нь бүр ч ойлгомжтой бизээ хэмээн найдна.

Ардчилал, зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй орж, даяарчлалын нөлөөнд хүссэн, хүсээгүй хамрагдан өртөгдөх манай орны хувьд мэдээллийн их эргүүлэгт бид нэгэнт ороод явчихав. Өнөөдөр манай улсад төрийн ба хувийн өмчийн олон телевиз үйл ажиллагаа явуулж, 60 орчим гадаад, дотоодын сувгаар мэдээлэл хүртэх бололцоотой болсны нэг нь ӨМӨЗО-ны телевизийн суваг юм. Хэдэн жилийн өмнө бид уг сувгаар гарч буй нэвтрүүлгийг үзээд зарим хэллэг илэрхийллийг нь гадарлах ч үгүй байж, зарим санааг нь гүжирдэн ойлгож, тэдгээрийн "сонин хачин"-ыг нь инээдэм наадам болгон ярьцгааж байсан бөлгөө. Гэтэл өнөөдөр "санасан даа хүрэх гэж тэд ч их мэрийсэн юм, сайн талаас нь би ч их дэмжсэн юм" гэсэн манай нэг киноны баатарын үг лүгээ аль аль талын хүчин зүтгэлээр үндсэндээ бие биенийгээ гайгүй ойлгох болж ирлээ.

Нөгөө талаар бүх төвшний харилцаа холбоо бидний хооронд өрнөн дэлгэрч хувийн болоод "хувьсгалын" шугамаар харилцан айлчлах, зочин гийчин урих, арилжаа наймаа эрхлэх, соёлын хамтын үйл ажиллагаа явуулах, сургууль дамжаанд суралцах мэтчилэн илүү өргөн хүрээнд харилцах болов. Эрдэм солилцооны үйл ажиллагаа ч өргөжих төлөвтэй байна. Энэ явцад манай ярианы болоод бичгийн хэлэнд ялгаатай зүйл багагүй байгаа нь ажиглагдаж байгаа юм. Тэр нь хэлний үгсийн аймгийн бүх төрөл ангилалд илэрч байдаг бололтой. Жишээ нь хэлний үгсийн аймгаар айхтар ялгахгүйгээр дараах хүснэгтэнд оруулсан зүйлийг харьцуулан ажиглацгаая л даа.

Өвөр Монголчуудын яриа, бичгийн хэлэнд	Бидний яриа, бичгийн хэлэнд
-Бүдүүн дэлгүүр	-Их дэлгүүр
-Үсэргээ	-Бүжиг
-Зусаал	-Зуслан
-Урлагчин	-Уран бүтээлч
-Асар	-Байшин
-Хоолон гэр	-Хоолны газар, гуанз, ресторан, кафе
Албан гэр	-Ажлын газар, байгуулагын байр
-...омогшиж байна	-...баяртай байна, бахархал төрж байна
-...-ийг шувтлая	-...-ийг дуусгая, төгсгөө, өндөрлөө
-Чи надад мордчихоо	-Чи надтай (ханилан) суучих л даа
-Чи өнхөрдчихөө	-Зайл чи, тонил чи
-Гоожуурдах	-Шалгаруулалтанд тэнцэхгүй байх, унах
-Барах	-Дуусгах
-Дийлэхгүй байх	-Чадахгүй байх, амжихгүй байх
-Би танд (нэг) утас авъя даа	-Би тантай (нэг) утсаар ярья, ...тань руу (нэг) залгъя даа
-Үнээр	-Үнэхээр
-Манай хоёр	-Бид хоёр
-Би чамтай учиртай	-Би чамтай ярих юм байна

Энэ мэт жишээг олон олноор толилуулж болох боловч өгүүллийн хэмжээнд нийцүүлэн цөөнийг оруулсан болохоо хүлцэн өчье. Өвөрлөгч нөхдийнхөө яриа, бичгийг иймэрхүү байдлаар ойлгож болмоор санагдсан, гэхдээ хэрэв бид буруу ухаарсан бол эрхэм авхай та өршөөн соёрхож илааршуулан болгооно уу.

Америкийн эрдэмтдийн судалгаагаар хүмүүсийн харилцаа (communication)-ны зорилго бүрэн хэрэгжихэд вербаль буюу хэлэхүйн харилцаа 35%, харин нон вербаль буюу хэлэхүйн бус харилцаа 65%-ийн ач холбогдолтой болохыг тогтоосон байдаг /1. 116/. Энэ үнэний талтай бололтой. Дээрх харьцуулсан оноолтыг хийхдээ хэл, угсаа улбаа нэгтэй өвөрлөгч нөхдийнхөө нон вербаль харилцаа буюу тэдний дохио зангаа, нүдний харц, нүүрийн хувирал, биеийн тавил болон хөдлөл, харьцах зай, орон зайг эзэмдэж буй байдал, хувцаслалт, үнэр зэргээс гадна, хэлэхүйн харилцаанд өнгө зүс оруулдаг паравербаль харилцаа буюу үгийн дуудлага, хоолойн тембр, ярианы хурдац хийгээд үндэслэгээ /2. 171/ мэтсийг ашиглан байж тодорхой үр дүнд хүрсэн нь илт байгаа юм.

Саяхавтар ӨМӨЗО-ны хоёр судлаач манайд эрдмийн зэрэг хамгаалах үеэр эрдэм шинжилгээний нэр томъёоны хувьд олон тооны ялгаа үзэгдэж багагүй бэрхшээлтэй тулгарч байсныг харлаа. Тэдний хамгаалалтын хурал дээр манай зарим эрдэмтэд уйгаржин монгол бичгээрээ ярьж байгаа учраас бид цаашдаа тэднээс зарим нэр томъёогоо авч хэрэглэх хэрэгтэй гэсэн санаа ч цухуйлгаж байлаа. Тухайлбал, "хос даажилт", "аж үйлсжилт" гэх мэтийн нэр томъёонуудыг агуулгын хувьд хүлээж аваад л хамгаалуулсан билээ. Ямар ч гэсэн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд энэ мэт бэрхшээлийг гэтлэх нь бидний өмнө зайлшгүй тулгарч байгаа асуудал мөн бөгөөд цаашдаа ач тусаа өгөх нь дамжиггүй биз ээ.

Анхандаа бид "асар" гэдгийг нь "майхан", үсэргээ гэдгийг хурдан морины үсэргээ, "албан гэр" гэдгийг ажлын газраас нь түр бариулж байгаа гэр юм байх гэж ойлгохоор байлаа. Бас "би танд нэг утас авъя" гэснийг нь гар утас бэлэглэх нь үү дээ гэх шиг, "манай хоёр" гэж ярихаар нь намайг бус, өөрийгөө болон өөр нэг өвөр монгол хүнийг яриад байна уу даа гэлтэй ойлгож байсан нь үнэн юм шүү.

Тэр үед бид бие биентэйгээ ёстой л "сэтгэлээрээ" ойлголцож байлаа. Энд нэг зүйл ихэд сонирхол татаж байгаа юм. Хэдийвээр бидний хооронд ярьж бичих илэрхийлэлд зарим зөрөөтэй зүйл байсан ч үйл хөдлөл, заншил, бэлгэдэл, ёслол, зан үйл, сэтгэлгээний хэв шинж, ахуй байдал зэрэг нь бусад ард түмнээс илүү ойр төдийгүй, зарим талаар адил байсан нь хялбар ойлголцох боломжийг бүрдүүлж байсан байж болно. Үүнийг соёлын нийтлэгтэй холбон үзэж болох ч "сэтгэл" гэдэг бол соёлын чухал элемент юм байна гэдгийг давхар нотлож байж болно. Тэгэхлээр энэ нь соёл судлалын шинжлэх ухааны нэгэн сонирхолтой судлагдахуун байж болох юм.

Өөр нэг асуудал бол авиан зүйн асуудал юм. Жишээ нь өвөр монголын зарим хүн “эм” гэдгийг “өм” гээд байх шиг, “үүдээ нээ” гэдгийг “өөдөө нөө” гээд байгаа юм шиг дуудах нь бий. Манай хэл шинжлэлд энэ тухай асуудлыг эрх биш авч үздэг байх гэж бодном. Ажиглалтаас онол, үзэл баримтлал төрөх нь зүй биз ээ.

#### Ном зүй

1. Грушевицкая Т.Г., Попков В.Д., Садохин А.П. Основы межкультурной коммуникации: Учебник для вузов. Подред. А.П. Садохина. – М.: ЮНИТИ-ДАНА, 2003. – 352 с.
2. Т.Дорждагва. Соёл судлалын бүтээлийн эмхэтгэл. 2003/III-2005/IV. –УБ.: МУИС-ийн Хэвлэх үйлдвэр, 2005. – 358 тал
3. Т.Дорждагва, Л.Эрдэнэтуяа.Төрөөс баримтлах хэлний бодлогод нэмэрлэх санал // Төрөөс баримтлах хэлний бодлогын асуудлууд (Илтгэл, хэлсэн үгийн эмхэтгэл). – УБ.: ХИС-ийн хэвлэл, 2005. – 85 тал.
4. Хоруженко К.М. Культурология. Энциклопедический словарь. – Ростов на Дону: Изд-во “Феникс”, 1997. – 640 с.
5. Энциклопедический словарь по культурологии. Подред.проф.А.А.Радугина. – М.:“Центр”, 1997. – 480 с.